



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 68

Номгон

Үндсэн хөрөнгө акталж
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам”-ын 1.3, 6.1, 6.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Жинст сумын төвд улсын төсвийн санхүүжилтээр 2480,0 сая төгрөгийн өртөг бүхий 240 хүүхдийн сургуулийн барилгыг хуучин сургуулийн газар дээр барихаар зураг төсөв хийгдсэн тул сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1978 онд ашиглалтад орсон 532 451 831,9 төгрөгийн өртөг бүхий элэгдлээ 100 хувь нөхсөн хичээлийн байрны хуучин барилга, улсын төсвийн санхүүжилтээр 1020,0 сая төгрөгийн өртөг бүхий Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүмүүнлэгийн ордон барихаар зураг төсөв хийгдсэн тул 2009 онд ашиглалтад орсон 2 440 620 төгрөгийн анхны үнэтэй 2 133 774,09 төгрөгийн үлдэгдэл өртөгтэй “Тэгш дүүрэн төв”-ийн барилга, Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн хичээлийн барилгыг улсын төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр шинээр барих болсон тул тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1981 онд ашиглалтад орсон 2018 онд дахин үнэлэгдэж 21 257 000 төгрөгөөр үнэлж бүртгэсэн Үйлдвэр сургалтын байрны барилга зэргийг тус тус акталж данснаас хассугай.

2. Жинст сумын хичээлийн байрны барилга, Тэгш дүүрэн төвийн барилга, Номундалай цогцолбор сургуулийн Үйлдвэр сургалтын байрны барилгын материалыг өмч хамгаалах байнгын зөвлөл, Орон нутгийн өмчийн газрын хяналтан дор хүлээн авч “Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын хашаанд хурааж үнэлгээ дүгнэлт гарган худалдан борлуулж орлогыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын 100030051006 тоот дансанд төвлөрүүлэхийг Жинст сумын Иргэдийн

төлөөлөгчдийн хурлын дарга /Р.Батжаргал/-д зөвлөж, Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга /Д.Амарсанаа/, Номундалай цогцолбор сургуулийн захирал /Ц.Алтангэрэл/ нарт үүрэг болгосугай.

3. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д дор дурдсан ажлыг зохион байгуулахыг даалгасугай.

3.1. Актлагдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

3.2. Энэ тогтоолын хэрэгжилтийг 2019 оны 08 дугаар сард багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлэх.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.ОТГОНБАЯР